



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сэлэнгэ аймгийн Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: СЭА-2022/92-НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.selenge@audit.gov.mn
Сүхбаатар сум
2022 он

Дарга, тэргүүлэх аудитор: Ч.Энхтуяа
Утас: 7036-3040 Цахим хаяг: enkhtuyach@audit.gov.mn

Аудитын менежер: Б.Батмөнх
Утас: 7036-3036 Цахим хаяг: batmunkhb@audit.gov.mn

Аудитор: О.Анхбаяр
Утас: 7036-2442 Цахим хаяг: ankhbayaro@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1.Аудитын санал дүгнэлт	3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	6
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	7
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	8
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	10
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	11
3. Аудитын тайлан.....	12
3.1 Ерөнхий зүйл.....	12
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	12
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	14
3.4 Материаллаг байдал	14
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	14
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	15
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	16
3.8 Аудитын гол асуудал	17
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	17
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	17
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	18
4. Аудитын илрүүлэлт	18
4.1 Залруулсан алдаа	18
4.3 Албан шаардлага	18
4.4 Зөвлөмж.....	19
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	20

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ЗГ	Засгийн Газар
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ҮОМШӨ	Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчин



СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

213200 Сэлэнгэ аймаг, Сүхбаатар сум
Цагаан Эрэг II баг
Утас: 7036-3040, Факс: (976)-7036-3040
E-mail: Selenge@audit.gov.mn

2022-02-17 № СЭА-2022/92-НА-СТА-ТШЗ

танай _____-ны № _____-т

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сэлэнгэ аймгийн Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Сэлэнгэ аймгийн Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.ЭНХТУЯА

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	47,844,003.00	42,140,866.23
35	БАРАА МАТЕРИАЛ	47,844,003.00	42,140,866.23
35100	Түүхий эд материал	15,547,110.00	7,867,210.00
35110	Тусгай зориулалттай материал	15,547,110.00	7,867,210.00
35400	Хангамжийн материал	32,296,893.00	34,273,656.23
35420	Аж ахуйн материал	30,296,893.00	28,690,856.23
35450	Барилгын засварын материал	2,000,000.00	3,008,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	718,417,580.93	769,461,833.41
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	718,417,580.93	769,461,833.41
39200	Биет хөрөнгө	668,915,580.93	719,959,833.41
39201	Барилга, байгууламж, орон сууц	596,803,135.60	596,803,135.60
39202	Хуримтлагдсан элэгдэл	-27,239,356.44	-31,779,249.18
39203	Авто-тээврийн хэрэгсэл	23,500,000.00	23,500,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-4,651,041.73	-5,385,416.74
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	45,827,250.28	102,968,374.28
39206	Хуримтлагдсан элэгдэл	-8,909,710.20	-11,659,847.73
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	53,376,707.00	56,701,978.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-20,013,808.25	-21,226,485.66
39214	Бусад үндсэн хөрөнгө	18,684,631.00	18,684,631.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-8,462,226.33	-8,722,286.16
39300	Биет бус хөрөнгө	49,502,000.00	49,502,000.00
39301	Программ хангамж	563,340.00	563,340.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-563,340.00	-563,340.00
39303	Бусад биет бус хөрөнгө	49,502,000.00	49,502,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	766,261,583.93	811,602,699.64
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	766,261,583.93	811,602,699.64
51	Засгийн газрын хувь оролцоо	766,261,583.93	811,602,699.64
51100	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	200,497,379.82	200,497,379.82
51200	Хуримтлагдсан үр дүн	-13,675,660.60	31,665,455.11
51210	Өмнөх үеийн үр дүн	-54,907,492.13	-13,675,660.60
51220	Тайлант үеийн үр дүн	41,231,831.53	45,341,115.71
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	579,439,864.71	579,439,864.71
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	766,261,583.93	811,602,699.64

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	516,268,057.82	574,702,883.56
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	7,023,627.28	60,466,395.00
120	Нийтлэг татварын бус орлого	7,023,627.28	60,466,395.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	4,762,627.28	60,466,395.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	2,261,000.00	0.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	509,244,430.54	514,236,488.56
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	435,180,700.00	415,207,600.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	435,180,700.00	415,207,600.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	26,582,000.00	50,800,000.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	13,732,000.00	0.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	12,850,000.00	50,800,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	47,481,730.54	48,228,888.56
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	47,481,730.54	48,228,888.56
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	475,036,226.29	529,361,767.85
21	УРСГАЛ ЗАРДАЛ	475,036,226.29	529,361,767.85
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	454,747,593.18	525,552,130.46
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	163,387,575.16	178,215,870.35
210101	Үндсэн цалин	121,747,565.55	113,623,798.46
210102	Нэмэгдэл	22,094,601.61	33,108,797.72
210103	Унаа хоолны хөнгөлөлт	14,456,572.00	11,353,609.61
210104	Урамшуулал	5,088,836.00	20,129,664.56
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	22,372,936.23	22,009,561.45
210201	Тэтгэврийн даатгал	16,286,184.00	15,474,654.32
210202	Тэтгэмжийн даатгал	1,556,838.26	1,729,377.43
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,245,650.62	1,383,501.97
210204	Ажилгүйдлийн даатгал	298,487.62	311,093.50
210205	Эрүүл мэндийн даатгал	2,985,775.73	3,110,934.23
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	30,772,130.54	35,116,888.56
210301	Гэрэл, цахилгаан	1,749,823.60	2,523,823.91
210302	Түлш, халаалт	28,002,038.94	31,154,782.65
210303	Цэвэр, бохир ус	1,020,268.00	1,438,282.00
2104	Хангамж, бараа материалын зардал	18,200,100.56	21,874,281.14
210401	Бичиг хэрэг	2,523,000.00	3,842,600.00
210402	Тээвэр, шатахуун	3,120,000.56	3,052,980.14
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	947,690.00	1,993,746.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	163,800.00	0.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	981,790.00	0.00
210408	Бараа материал акталсны зардал	10,463,820.00	12,984,955.00

2105	Нормативт зардал	525,000.00	260,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	525,000.00	260,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	11,009,600.00	9,552,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	100,000.00	0.00
210604	Урсгал засвар	10,909,600.00	9,552,000.00
2107	Томилолт, зочны зардал	414,300.00	2,736,400.00
210702	Дотоод албан томилолт	414,300.00	2,736,400.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	191,332,464.94	244,823,986.44
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	190,773,789.94	244,391,986.44
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	432,000.00	432,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	81,675.00	0.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	45,000.00	0.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	16,733,485.75	10,963,142.52
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	0.00	1,466,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	16,733,485.75	9,497,142.52
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	20,288,633.11	3,809,637.39
2132	Бусад урсгал шилжүүлэг	16,767,400.00	0.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	15,367,400.00	0.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,400,000.00	0.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	3,521,233.11	3,809,637.39
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	3,521,233.11	3,809,637.39
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	41,231,831.53	45,341,115.71
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	41,231,831.53	45,341,115.71

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	200,497,379.82	579,439,864.71	-54,907,492.13	725,029,752.40
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	200,497,379.82	579,439,864.71	-54,907,492.13	725,029,752.40
9	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	41,231,831.53	41,231,831.53
10	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	200,497,379.82	579,439,864.71	-13,675,660.60	766,261,583.93
11	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	200,497,379.82	579,439,864.71	-13,675,660.60	766,261,583.93
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	200,497,379.82	579,439,864.71	-13,675,660.60	766,261,583.93
19	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	45,341,115.71	45,341,115.71
20	2021 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	200,497,379.82	579,439,864.71	31,665,455.11	811,602,699.64

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	509,244,430.54	514,236,488.56
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	509,244,430.54	514,236,488.56
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	435,180,700.00	415,207,600.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	435,180,700.00	415,207,600.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	26,582,000.00	50,800,000.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	13,732,000.00	0.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	12,850,000.00	50,800,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	47,481,730.54	48,228,888.56
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	47,481,730.54	48,228,888.56
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	468,725,530.54	514,161,488.56
21	УРСГАЛ ЗАРДАЛ	468,725,530.54	514,161,488.56
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	448,436,897.43	510,351,851.17
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	163,707,575.16	178,202,270.35
210101	Үндсэн цалин	122,067,565.55	113,610,198.46
210102	Нэмэгдэл	22,094,601.61	33,108,797.72
210103	Унаа хоолны хөнгөлөлт	14,456,572.00	11,353,609.61
210104	Урамшуулал	5,088,836.00	20,129,664.56
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	22,372,936.23	22,009,561.45
210201	Тэтгэврийн даатгал	16,286,184.00	15,474,654.32
210202	Тэтгэмжийн даатгал	1,556,838.26	1,729,377.43
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,245,650.62	1,383,501.97
210204	Ажилгүйдлийн даатгал	298,487.62	311,093.50
210205	Эрүүл мэндийн даатгал	2,985,775.73	3,110,934.23
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	34,572,130.54	35,116,888.56
210301	Гэрэл, цахилгаан	1,749,823.60	2,523,823.91
210302	Түлш, халаалт	31,802,038.94	31,154,782.65
210303	Цэвэр, бохир ус	1,020,268.00	1,438,282.00
2104	Хангамж, бараа материалын зардал	7,311,490.00	8,891,226.00
210401	Бичиг хэрэг	2,500,000.00	3,909,900.00
210402	Тээвэр, шатахуун	2,400,000.00	3,265,980.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	947,690.00	1,715,346.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	163,800.00	0.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,300,000.00	0.00
2105	Нормативт зардал	3,055,000.00	728,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	3,055,000.00	728,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	12,909,600.00	13,112,000.00
210604	Урсгал засвар	12,909,600.00	13,112,000.00
2107	Томилолт, зочны зардал	414,300.00	2,708,400.00
210702	Дотоод албан томилолт	414,300.00	2,708,400.00

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	204,093,865.50	248,117,504.81
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	202,594,690.50	247,685,504.81
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	432,000.00	432,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	81,675.00	0.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	45,000.00	0.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	940,500.00	0.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	0.00	1,466,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	0.00	1,466,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	20,288,633.11	3,809,637.39
2132	Бусад урсгал шилжүүлэг	16,767,400.00	0.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	15,367,400.00	0.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,400,000.00	0.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	3,521,233.11	3,809,637.39
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	3,521,233.11	3,809,637.39
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	40,518,900.00	75,000.00
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	40,518,900.00	75,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	40,518,900.00	75,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	40,518,900.00	75,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	40,518,900.00	75,000.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-40,518,900.00	-75,000.00

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан	Гүйцэтгэл зөрүү /хэтрэлт, хэмнэлт/	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	473,817,200.00	459,626,851.17	14,190,348.83	97.01
21	УРСГАЛ ЗАРДАЛ	473,817,200.00	459,626,851.17	14,190,348.83	97.01
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	473,817,200.00	459,626,851.17	14,190,348.83	97.01
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	178,985,800.00	178,202,270.35	783,529.65	99.56
210101	Үндсэн цалин	132,771,900.00	113,610,198.46	19,161,701.54	85.57
210102	Нэмэгдэл	46,213,900.00	33,108,797.72	13,105,102.28	71.64
210103	Унаа хоолны хөнгөлөлт	0.00	11,353,609.61	-11,353,609.61	
210104	Урамшуулал	0.00	20,129,664.56	-20,129,664.56	
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	24,163,200.00	22,009,561.45	2,153,638.55	91.09
210201	Тэтгэврийн даатгал	17,003,700.00	15,474,654.32	1,529,045.68	91.01
210202	Тэтгэмжийн даатгал	1,789,900.00	1,729,377.43	60,522.57	96.62
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,431,900.00	1,383,501.97	48,398.03	96.62
210204	Ажилгүйдлийн даатгал	358,000.00	311,093.50	46,906.50	86.90
210205	Эрүүл мэндийн даатгал	3,579,700.00	3,110,934.23	468,765.77	86.90
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	37,700,000.00	35,116,888.56	2,583,111.44	93.15
210301	Гэрэл, цахилгаан	3,000,000.00	2,523,823.91	476,176.09	84.13
210302	Түлш, халаалт	32,900,000.00	31,154,782.65	1,745,217.35	94.70
210303	Цэвэр, бохир ус	1,800,000.00	1,438,282.00	361,718.00	79.90
2104	Хангамж, бараа материалын зардал	8,973,300.00	8,891,226.00	82,074.00	99.09
210401	Бичиг хэрэг	3,873,900.00	3,909,900.00	-36,000.00	100.93
210402	Тээвэр, шатахуун	3,266,400.00	3,265,980.00	420.00	99.99
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,833,000.00	1,715,346.00	117,654.00	93.58
2105	Нормативт зардал	728,000.00	728,000.00	0.00	100.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	728,000.00	728,000.00	0.00	100.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	20,909,600.00	13,112,000.00	7,797,600.00	62.71
210604	Урсгал засвар	20,909,600.00	13,112,000.00	7,797,600.00	62.71
2107	Томилолт, зочны зардал	2,955,700.00	2,708,400.00	247,300.00	91.63
210702	Дотоод албан томилолт	2,955,700.00	2,708,400.00	247,300.00	91.63
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	197,473,700.00	197,392,504.81	81,195.19	99.96
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	197,013,700.00	196,960,504.81	53,195.19	99.97
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	460,000.00	432,000.00	28,000.00	93.91
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,927,900.00	1,466,000.00	461,900.00	76.04

210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,927,900.00	1,466,000.00	461,900.00	76.04
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	473,817,200.00	463,436,488.56	10,380,711.44	97.81
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	415,207,600.00	415,207,600.00	0.00	100.00
310003	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	415,207,600.00	415,207,600.00	0.00	100.00
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	58,609,600.00	48,228,888.56	10,380,711.44	82.29
320001	Орон нутгийн төсвөөс	58,609,600.00	48,228,888.56	10,380,711.44	82.29
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	33.00	33.00	0.00	100.00
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1.00	1.00	0.00	100.00
610001	Төсвийн байгууллага	1.00	1.00	0.00	100.00
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	16.00	16.00	0.00	100.00
620001	Удирдах ажилтан	1.00	1.00	0.00	100.00
620002	Гүйцэтгэх ажилтан	10.00	10.00	0.00	100.00
620003	Үйлчлэх ажилтан	5.00	5.00	0.00	100.00

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Код	Үзүүлэлт	Төсвийн гүйцэтгэл
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	50,800,000.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	50,800,000.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	50,800,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	50,800,000.00
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	50,800,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	50,800,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	50,800,000.00

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Сэлэнгэ аймгийн Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд төлбөрийн цахим баримт болон зардлын данстай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор О.Анхбаяр гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Б.Батмөнх, дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Сэлэнгэ аймгийн Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 19-ний өдрийн 14 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Сэлэнгэ аймгийн Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газрын эрхэм зорилго нь “Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийг дэмжин, иргэн бүрд хүрсэн шуурхай үйлчилгээг бий болгох”-д оршиж байна.

Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газрын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Хүүхдийн эрхийн тухай, хүүхэд хамгааллын тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулах, сурталчлах, нөлөөллийн үйл ажиллагааг зохион байгуулах,
- Хүүхдийн хөгжил, хамгааллын үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах, төлөвлөгөө хөтөлбөр гаргах, үе шаттай зохион байгуулах,
- Хүүхдийн тусламжийн утасны үйлчилгээг олон улсын стандартад нийцүүлэхэд олон улсын болон мэргэжлийн байгууллагаас арга зүй, туслалцаа дэмжлэг авах, хамтын ажиллагааг хөгжүүлэх, зорилтод дуудлагын хариу үйлчилгээний чанарыг сайжруулах,
- Өмчийн бүх хэлбэрийн хүүхдийн зусланг хүүхдийн амралт, аялал жуулчлал, сувилал, чийрэгжүүлэлтийн болон оюун ухаан, авьяас чадварыг хөгжүүлэх, амьдрах ухаанд суралцуулах, гэр бүлтэйгээ амрах чиглэлээр төрөлжсөн үйл ажиллагаа хувилбарт хөтөлбөр бүхий үйлчилгээний цогцолбор болгоход чиглэсэн бодлого, хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлэх,

- Хүүхэд залуучуудыг соёл урлаг, спортоор дамжуулан хөгжүүлэх, амьдрах арга ухаанд суралцуулах хөгжлийн үйл ажиллагааг хүүхдийн ордон, залуучуудын хөгжлийн төв болон бусад байгууллагыг түшиглэн орон нутагт хэрэгжүүлэхэд бодлого, удирдамж, арга зүйгээр ханган ажиллах,
- Эцэг эх, хүүхэд, залуучууд иргэд олон нийтэд зориулсан цахим болон алсын зайн сургалтын хөтөлбөрүүдийг боловсруулж, түгээх, соён гэгээрүүлэх үйл ажиллагааг зохион байгуулах,
- Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжил, хамгааллын үйлчилгээ, үйл ажиллагааг мэргэшсэн магадлан итгэмжлэгдсэн төрийн бус байгууллага, хуулийн этгээдээр гэрээлэн гүйцэтгүүлж, үр дүнг тооцох, нийтэд мэдээлэх,
- Эрсдэлтэй бүлгийн хүүхдийн эрхийг хамгаалах, дахин эрсдэлд өртөхөөс урьдчилан сэргийлэх, нийгэмшүүлэх үйлчилгээг сайжруулах,
- Хүүхдийн үндэсний болон орон нутгийн чуулганыг тогтмолжуулж, чуулганы шийдвэрийг бодлого, төлөвлөлтөд тусгах,
- Хүүхдийн төлөө үндэсний болон орон нутгийн зөвлөлийн бүрэлдэхүүнд хүүхэд, эцэг эх, хүүхдийн элчийн төлөөллийг оруулах, хүүхдийн элчийн үйл ажиллагааг төлөвшүүлэх,
- Хүүхэд залуучуудын сонирхлын бүлэг, клуб холбоо зэрэг байгууллагын үйл ажиллагааг дэмжин хамтран ажиллах,
- Хүүхэд өсвөр үеийнхнийг хэвлэл мэдээлэл, цахим дахь мэдээллийн сөрөг нөлөөллөөс хамгаалах, эцэг эхийн оролцоотой хяналтыг төлөвшүүлэх,
- Монгол хүүхдийн хөгжлийн түвшинг тодорхойлох, үнэлэх аргачлал боловсруулах гэх мэт.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт орсон байна.

Үүнд:

- Монгол Улсын 2021 оны Төсвийн тухай хуулиар төсөв, санхүүжилттэй холбоотой,
- Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалаар “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар” шинэчлэгдсэн,
- Сангийн сайдын дэргэдэх Нягтлан бодох бүртгэл, аудитын стандартын хорооны 2020 оны 10 дугаар тогтоолоор батлагдсан УСНББОУС-ын өөрчлөлт шинэчлэл хийгдсэн гэх мэт.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэлийн үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж үзэж байна.

Тус байгууллагын үйл ажиллагаанд мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Тайлант онд дээд шатны төсвийн захирагчдын зүгээс дотоод хяналт, шалгалт хийгдээгүй байна.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Сэлэнгэ аймгийн Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газрын 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн, хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 475,036.2 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 7,125.5 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 4.987.9 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газрын 2021 оны санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 45,341.1 мянган төгрөгөөр буюу 5.9 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс бараа материал, үндсэн хөрөнгө, засгийн газрын оролцоо дансдад материаллаг өөрчлөлт гарсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

	/мянган төгрөг/		
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө			
Авлага			
Урьдчилгаа			
Бараа материал	47,844.0	42,140.9	-5,703.1
Үндсэн хөрөнгө	718,417.6	769,461.8	51,044.2
Нийт хөрөнгө	766,261.6	811,602.7	45,341.1
Өр төлбөр			
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	766,261.6	811,602.7	45,341.1
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	766,261.6	811,602.7	45,341.1

Бараа материалын данс 42,140.9 мянган төгрөг болж 5,703.1 мянган төгрөгөөр буурсан нь Өмч хамгаалах байнгын зөвлөлийн тогтоолоор 12,985.0 мянган төгрөгийн бараа материал акталсан болон төсвийн хөрөнгөөр 154,391.4 мянган төгрөгийн бараа материал худалдан авч, байгууллагын үйл ажиллагаанд 160,094.5 мянган төгрөгийн бараа материал зарцуулснаас шалтгаалсан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл /анхны өртгөөр/ 848,798.5 мянган төгрөг болж өмнөх оноос 60,541.4 мянган төгрөгөөр өссөн нь Дэлхийн зөн ОУБ-аас 5,858.4 мянган төгрөгийн үнэ бүхий тавилга эд хогшил, машин тоног төхөөрөмж, Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газраас 54,608.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмж шилжүүлэн авсан, урсгал төсвийн худалдан авалтаар 75.0 мянган төгрөгийн ном худалдан авснаас тус тус шалтгаалсан байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 811,602.7 мянган төгрөг болж 45,341.1 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалсан байна.

Санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 58,434.8 мянган төгрөгөөр буюу 11.3 хувиар өссөн нь үнэ төлбөргүй хүлээн авсан хөрөнгийн орлого 53,442.8 мянган төгрөгөөр, нэмэлт санхүүжилтийн орлого 24,218.0 мянган төгрөгөөр тус тус өссөн, урсгал үйл ажиллагааны санхүүжилт 19,226.0 мянган төгрөгөөр буурсан зэргээс шалтгаалсан байна.

Нийт зардал өмнөх оноос 54,325.5 мянган төгрөгөөр буюу 11.4 хувиар өссөн байна. Энэ нь дээд шатны төсвийн захирагчаас 50,800.0 мянган төгрөгийн ажил үйлчилгээ, төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх санхүүжилт ирснээс шалтгаалж бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний зардал өссөнөөс голлон шалтгаалсан байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр болон нийт зарлагыг 802,410.6 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлснийг 324,915.6 мянган төгрөгөөр бууруулж, 477,495.0 мянган төгрөгөөр баталсан байна.

Тайлант онд батлагдсан төсвийг аймгийн ИТХ-ын 2021 оны 07 дугаар сарын 21-ний өдрийн “Сэлэнгэ аймгийн 2021 оны тодотгосон төсөв батлах тухай” 16 дугаар тогтоолоор тодотгож, 3,677.8 мянган төгрөгөөр бууруулан 473,817.2 мянган төгрөгөөр эцэслэн баталсан нь хангамж, бараа материалын зардлыг 157.0 мянган төгрөгөөр, томилолт, зочны зардлыг 268.7 мянган төгрөгөөр, бараа үйлчилгээний бусад зардлыг 5,160.8 мянган төгрөгөөр тус тус бууруулж, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийн зардлыг 1,594.7 мянган төгрөгөөр нэмэгдүүлсэнтэй холбоотой байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх Хүүхэд хөгжил хамгааллын хөтөлбөрийн 5 арга хэмжээг санхүүжүүлэхээр **473,817.2** мянган төгрөгийн төсөв баталснаас 415,207.6 мянган төгрөгийг тусгай зориулалтын шилжүүлгээс 58,609.6 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөр санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр тусгай зориулалтын шилжүүлгээр 415,207.6 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 48,228.9 мянган төгрөг зэрэг нийт 463,436.5 мянган төгрөгийн санхүүжилт авч урсгал үйл ажиллагаанд **459,626.9** мянган төгрөгийг зарцуулж, оны эцэст 3,809.6 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газраас “Нөлөөллийн арга хэмжээнүүд зохион байгуулах” 11,550.0 мянган төгрөг, “Түр хамгаалах байр, нэг цэгийн үйлчилгээний төвүүдийн хүүхэд хамгааллын хариу үйлчилгээнд дэмжлэг үзүүлэх” 29,300.0 мянган төгрөг, “Орон нутгийн хамтарсан багийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх” 5,000.0 мянган төгрөг зэрэг нийт 50,800.0 мянган төгрөгийн санхүүжилт авч, зориулалтын дагуу зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

- Үндсэн хөрөнгийн ангилалд ашиглаж байгаа боловч үлдэх өртөг нь “0” үлдэгдэлтэй болсон 27,281.6 мянган төгрөгийн анхны өртөгтэй, 14 нэр төрлийн хөрөнгүүдийг ашиглаж байгаа нь УСНББОУС-17 “Үндсэн хөрөнгө”-ийн 49 дэх “... дахин үнэлэгдсэн хөрөнгийн бодит үнэ цэнэ нь дансны үнээсээ материаллаг ялгаатай байвал цаашид дахин үнэлэх зайлшгүй шаардлагатай” гэсэн заалттай нийцэхгүй байна. Иймд “0” үлдэгдэлтэй хөрөнгийг цаашид ашиглах бол дахин үнэлэх эсвэл акталж устгах асуудлыг эрх бүхий байгууллага, албан тушаалтанд тавьж шийдвэрлүүлэх шаардлагатай байна.
- Тайлант онд төлбөрийн баримтын цахим системд шивэгдсэн нийт 39,301.1 мянган төгрөгийн бараа материалын худалдан авалтад тус байгууллагын ажилчдын хувийн 2,296.4 мянган төгрөгийн худалдан авалт орж шивэгдсэн байгаа нь анхан шатны баримтгүй болон баримтын бүрдэлгүй орлого зарлагын гүйлгээг хүлээн зөвшөөрч данс бүртгэлд тусгах эрсдэлийг үүсгэж байна. Иймд төлбөрийн баримтын цахим системийг үнэн зөв хөтлөх,

алдаатай эсвэл буруу шивэгдсэн баримтуудыг тухай бүр залруулж байх шаардлагатай байна.

3.8 Аудитын гол асуудал

Тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудлууд байхгүй болно.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газрын мэдээлбэл зохих 20 төрлийн 149 мэдээлэл байршуулахаас 148 мэдээллийг хугацаанд нь, 1 мэдээллийг хугацаа хоцроон мэдээлсэн байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

3.9.2 Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын хэрэгжилт

Сэлэнгэ аймгийн Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газрын тайлант оны үйл ажиллагаанд 473,817.2 мянган төгрөгийн төсөв батлагдаж, гүйцэтгэлээр 459,626.9 мянган төгрөгийг зарцуулан, төсвийн төлөвлөгөөг 3.0 хувиар хэмнэсэн нь ЗГ-ын 2021 оны 43 дугаар тогтоолын 1.1-д: “.....батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар тооцож, урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг төлөвлөн хуваарилах” гэж заасныг бүрэн хэрэгжүүлээгүй байна.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар тогтоосон 664.3 мянган төгрөгийн 1 төлбөрийн актыг бүрэн биелүүлсэн байна. Аудитаар өгсөн 1 зөвлөмжийн хэрэгжилт 100 хувьтай байна.

Хүснэгт 2. Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн акт, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Хэрэгжилтийн хувь
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
					/мянган төгрөг/

Акт	1	664.3	1	664.3	100.0
Зөвлөмж	1	0.0	1	0.0	100.0
Нийт дүн	2	664.3	3	664.3	100.0

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал гараагүй болно.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 120,883.3 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс 1,415.5 сая төгрөгийн алдааг залруулж, 3,927.4 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлэн, 115,540.4 сая төгрөгийн алдаа зөрчилд 2 зөвлөмж өгсөн.

4.1 Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

- Төлбөр тооцоог урьдчилан хянаагүй, цалинг зөрүүтэй тооцоолсны улмаас 13 албан хаагчид нийт 680.7 мянган төгрөгийн ээлжийн амралтын олговор, 210.0 мянган төгрөгийн хоолны хөнгөлөлт зэрэг нийт **890.7** мянган төгрөгийг дутуу тооцож, олгосныг аудитын явцад нөхөн олгуулав.
- Өндөр настны тэтгэврээ тогтоолгосон боловч Ажил гүйцэтгүүлэх гэрээгээр ажиллаж буй бичиг хэргийн ажилтан Х.Одончимэгт мэргэшлийн зэргийн нэмэгдэл **524.8** мянган төгрөг олгосныг аудитын явцад нөхөн суутгуулав.

4.3 Албан шаардлага

1. Аймгийн 17 сум, 6 тосгоны 38 хамтарсан багт бичиг хэргийн материал олгохоор анхан шатны баримт бүрдүүлэн 5,054.0 мянган төгрөгийн зардал гаргасан боловч **2,660.0** мянган төгрөгийн бичиг хэргийн материалыг Алтанбулаг, Орхонтуул, Мандал сумын түр хамгаалах байр, Хүүхэд хөгжлийн төвийн бичиг хэргийн зардалд зарцуулсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь “*Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах*”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.1 дэх “*Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн зөв гаргах үндэслэл болно*”, 13.7 “*Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно*” гэсэн заалтыг зөрчсөн ба “Үнэлгээ ба хуваарилалт” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах, гүйцэтгэлийг анхан шатны баримтад үндэслэн үнэн зөв бүрдүүлж, тайлагнаж байх албан шаардлага хүргүүлэх.

2.Төсөвт зохицуулалт хийлгэлгүйгээр буюу дээд шатны төсвийн захирагчийн зөвшөөрөлгүйгээр нийгмийн бүлэгт чиглэсэн хөтөлбөрийн НДШ-ийн зардлаас үндсэн үйл ажиллагааны цалингаас төлөх НДШ-ийн зардалд **1,267.4** мянган төгрөгийг зардлын бүлэг хооронд гүйлгэн зарцуулж, гүйцэтгэлийг бодитоор тайлагнаагүй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 42 дугаар зүйл “*Төсвийн захирагчийн төсөвт зохицуулалт хийх*”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн

13.1 дэх “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн зөв гаргах үндэслэл болно”, Сангийн сайдын 2018 оны 134 дүгээр тушаалаар баталсан Төсвийн захирагчийн төсөвт зохицуулалт хийх журмын 3.1.6 дахь “... дээд шатны төсвийн захирагчийн зөвшөөрлийг албан бичгээр авсан байх” гэсэн заалтыг зөрчсөн ба “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Шаардлагатай тохиолдолд холбогдох албан тушаалтнаас зөвшөөрөл авч төсөвт зохицуулалт хийлгэж байх, гүйцэтгэлийг анхан шатны баримтад үндэслэн үнэн зөв бүртгэж, тайлагнаж байх албан шаардлага хүргүүлэх.

4.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Анхан шатны баримт, төлбөрийн цахим баримттай холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт: Тайлант онд **115,090.1** мянган төгрөгийн бараа материалын худалдан авалтыг холбогдох үзүүлэлтүүдийг тусгасан төлбөрийн баримтаар баталгаажуулаагүй, цахим системд шивэгдээгүй байна.

1.2. Өгсөн зөвлөмж: Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаал 1 дүгээр хавсралтын 6.5 дахь “Төлбөрийн баримт нь бараа, ажил, үйлчилгээний төлбөр, тооцоо хийгдсэнийг нотлох анхан шатны цаасан болон цахим баримт юм. Төлбөрийн баримтад борлуулагч, худалдан авагчийг таних тэмдэг, татвар төлөгчийн дугаар, төлбөр тооцоо хийгдсэн он, сар, өдөр, бараа, ажил, үйлчилгээний нэр, код, тоо хэмжээ, үнэ, татварын дүнг тусгана. Төлбөрийн баримтыг цахим гарын үсэг эсхүл тусгай нууцлалын QR кодоор баталгаажуулах бөгөөд Монгол Улсын Стандарт MNS 6529:2015 “Татварын нэгдсэн системд ашиглах төлбөрийн баримтын ерөнхий шаардлага”-д заасан загварын дагуу бүртгэлийн машинаар хоёр хувь үйлдэнэ”, Татварын ерөнхий хуулийн 28 дугаар зүйл 28.5 дахь “Татвар төлөгч борлуулалт хийх тухай бүрд хэрэглэгчийн системээс дахин давтагдашгүй дугаар бүхий төлбөрийн баримтыг хэвлэж өгөх, эсхүл цахимаар илгээх үүрэгтэй” гэж заасны дагуу төлбөрийн цахим баримтыг үндэслэж ажил гүйлгээг бүртгэх шаардлагатай ба “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

2. Зардлын данстай холбоотой асуудал

2.1. Илрүүлэлт: Үндсэн цалин, хоолны хөнгөлөлтийг зөрүүтэй тооцоолсны улмаас 6 албан хаагчид **450.3** мянган төгрөгийн цалингийн өр үүсэж болзошгүй ба “Эрх ба үүрэг” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

2.2. Өгсөн зөвлөмж: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д “Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах” гэсэн заалтыг зөрчиж байгаа тул ажил

гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулж, зарцуулалтад бүртгэлээр тавих хяналтыг сайжруулах.

Дээрх зөвлөмжүүдийн биелэлтийг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 06 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Д/Д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газар	6	120,883.3	2	1,415.5	-	-	2	3,927.4	2	115,540.4